

Санхүүгийн хэлтэс

2025 ОНЫ ЖИЛИЙН ЭЦЭС-Н ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

№	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин		Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/	Гүйцэтгэл-ийн хувь	
					Эхний хагас жил	Сүүлийн хагас жил		Өөрийн үнэлгээ	ХШҮ
<b>Гурав. Хуулиар тусгайлан олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээ</b>									
3.1.	Салбарын бодлого, хөтөлбөр, стратегийг хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүгийн эх үүсвэрийг төлөвлөх, санхүү, хөрөнгийн удирдлага, зохицуулалт, төсөв, санхүүгийн мэдээллээр хангах, шийдвэр гаргахад дэмжлэг	-	-	-	100%	100%	Салбарын бодлого, хөтөлбөр, стратегийг хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүгийн эх үүсвэрийг төлөвлөх, санхүү, хөрөнгийн удирдлага, зохицуулалт, төсөв, санхүүгийн мэдээллээр хангах, шийдвэр гаргахад дэмжлэг үзүүлэх, батлагдсан хөрөнгө оруулалтын	100%	100%

	үзүүлэх, батлагдсан хөрөнгө оруулалтын болон урсгал зардлыг санхүүжүүлэх, гүйцэтгэлийг хянах, үр дүнг тайлагнах;						болон урсгал зардлыг санхүүжүүлэх, гүйцэтгэлийг хянах, үр дүнг тайлагнан ажилласан.		
3.1.1	Байгууллагын санхүү, төсвийн асуудлыг эрхлэн гүйцэтгэж, өдөр тутмын хэвийн үйл ажиллагааг явуулна.	Үйл ажиллагааны зардлаар	Хэрэгжилтийн явц, хувиар	2024 оны байдлаар гадаад, дотоодын байгууллагуудтай байнгын хамтын ажиллагаатай ажиллаж байна.	-	Байгууллагын дотоод үйл ажиллагааг 100 хувьд хүргэнэ. /Дээшлүүлсэн хувь 100 хувь/	Эдийн засаг, хөгжлийн яамны болоод Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд хамаарах харьяа байгууллагуудын /нийт 30 байгууллага/ санхүү, төсвийн асуудлыг тухай бүр шийдвэрлэж, өдөр тутмын хэвийн үйл ажиллагааг ханган ажилласан.	100%	100%
3.1.2	Яамны албан хаагчдын цалин, тэтгэмжийг бодож олгох, нийгмийн даатгалын	Үйл ажиллагааны зардлаар	Хэрэгжилтийн хувь	Цалин олголт, НДШ, татварын тайлан тухай бүр гаргаж, тайлагнасан.	-	Цалин олголт, НДШ тайлан, татвар тайлан гаргасан хувь /100 хувь/	Яамны ажилтан, албан хаагчдын цалин, тэтгэмжийг тухай бүр хуулийн дагуу бодож олгосон бөгөөд нийгмийн	100%	100%

	<p>шимтгэл, хүн амын орлогын албан татварын тайлангуудыг тайлагнана.</p>						<p>даатгалын тайлан, ХХОАТ-ын тайлангуудын хуулийн хугацаанд тайлагнан ажилласан. Тодруулбал, 2025 оны 11 сарын 30-ны өдрийн байдлаар өссөн дүнгээр нийт 123 албан хаагчдад цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал бодож олгохдоо 4,900.6 сая төгрөгийн батлагдсан төсвөөс үндсэн цалинд 2,981.1 сая, нэмэгдэлд 846.0 сая, унаа хоолонд 849.5 сая, урамшуулалд 217.4 сая нийт 4,894.1 сая төгрөгийн 99.9 % гүйцэтгэлтэй байна. Түүнчлэн Нийгмийн даатгалд 139 албан хаагчийн ажил олгогчоос 621.9 сая төгрөг, даатгуулагчаас 574.7 сая төгрөг</p>		
--	--	--	--	--	--	--	---	--	--

							нийт 1,196.6 сая төгрөгийг, татварын албанд ХХОАТ-ын 329.2 сая төгрөгийг тус тус тооцож шилжүүлэн хуулийн хугацаанд нь тайлагнаж ямар нэг өр төлбөр үлдэгдэлгүйгээр хэрэгжилтийг ханган ажилласан. Мөн албан хаагчдын ажлын цагийн тооцооллыг ер-pomongolia системээр тогтмол бүртгэн, бүртгэлтэй холбоотой холбогдох зааварчилгааг тухай бүр албан хаагчдад өгч, цалингийн тооцооллын мэдээллийг албан хаагчдад сар бүр хүргүүлэн(ажилтан албан хаагчдын и-мэйл хаягаар) ажилласан.		
3.1.3	Байгууллагын шилэн	Үйл ажиллагаан	Шилэн дансны мэдээллийг	Тухай бүр мэдээлэл	-	Тайланг тухай бүр хугацаанд	Байгууллагын шилэн дансны	100%	100%

	дансны мэдээлэл оруулна.	ы зардлаар	хугацаанд оруулсан байх, хувиар	оруулсан.		www.shilendans.gov.mn сайтад байршуулна./ 100 хувь/	<p>мэдээллийг төсвийн ерөнхийлөн захирагч болон төсвийн байгууллага гэсэн 2 ангиллаар жил бүр-7, хагас жил-4, сар бүр-3, тухай бүр-5 хэсгийн мэдээллийг оруулахаас сар болон тухай бүрийн мэдээллийг цаг хугацаанд оруулсан болно. Тухай бүрдээ шилэн дансанд доорх байдлаар ил тод болгож оруулсан: 1. Сар бүрийн төсвийн хөтөлбөр, зориулалтаар батлагдсан төсөв гүйцэтгэл хэмнэлт хэтрэлтийн тайлан 2. Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын мөнгөн гүйлгээ 3. Цалингийн зардлаас бусад</p>		
--	--------------------------	------------	---------------------------------	-----------	--	---	---	--	--

							<p>таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын мөнгөн гүйлгээ 4. Тухайн байгууллагын хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэх төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээнд орсон өөрчлөлт 5. Худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын тайлан, дүгнэлт болон бусад хяналт шалгалтын дүн тухайн сард шилэн дансны мэдээллийн хугацаандаа мэдээлсэн болно.</p> <p>6. Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 118 харилцагчийн 4,319.0 сая төгрөгийн зарлагын мөнгөн гүйлгээг ил тод болгож илтгэсэн.</p>		
--	--	--	--	--	--	--	---	--	--

							<p>7. Хөрөнгө оруулалтын зарлага, санхүүжилтийг төсөл, объект тус бүрээр байршуулж, ил тод болгосон. Түүнчлэн яамны худалдан авах ажиллагааны төлөвлөгөө (байгууллагын нийт 2.9 тэрбум төгрөгийн 73 төсөл, арга хэмжээ), хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөгөө(нийт 20.0 тэрбум төгрөгийн төсөвтэй 40 ТЭЗҮ төсөл, арга хэмжээ, шилжих 2 төсөл арга хэмжээ), концессын зүйлийн жагсаалт, Байгууллагын батлагдсан төсөв (2025 оны баталсан 23.3 тэрбум, 2025 оны тодотгол 17.4</p>		
--	--	--	--	--	--	--	--	--	--

							тэрбум зардлын задаргаа), дараа жилийн төсвийн төсөл (ТЭЗ санал нийт 377.7 тэрбум, үүнээс хөрөнгийн зардал 238.2 тэрбум), тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт, хөрөнгийн болон урсгал зардалд тусгагдсан арга хэмжээний тендерийн ерөнхий мэдээлэл, Бонд зээл, өрийн бичиг, баталгаа, төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, өмч, хөрөнгө мөнгө зарцуулах, өр авлага үүсгэсэн аливаа шийдвэр зэрэг мэдээллийг хугацаанд ил тод болгон мэдээллэн ажилласан.		
3.1.4	Газрын чиг үүрэг хамаарах худалдан авах ажиллагааг зохион	Үйл ажиллагааны зардлаар	Худалдан авах ажиллагааг амжилттай зохион байгуулсан байх, хувиар	Худалдан авах ажиллагааг амжилттай зохион байгуулж, гүйцэтгэгчтэй гэрээ	-	Худалдан авах ажиллагааг амжилттай зохион байгуулж, гүйцэтгэгчтэй гэрээ байна. /100 хувь/	Сайдын 2025 оны А/21 дугаар тушаалаар яам болон харьяа 8 байгууллагуудын 2025 оны бараа, ажил үйлчилгээ	100%	100%

	байгуулна.			байгуулсан.			<p>худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг нийт 38,471.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй батлуулсан. Мөн сайдын 2025 оны А/49 дугаартай тушаалаар тус төлөвлөгөөнд нэмэлт өөрчлөлт оруулж, нийт 1,370.9 сая төгрөгийн төсвийг хасаж, 187.8 сая төгрөгийн төсөл, арга хэмжээг нэмж өөрчлөлт оруулсан. ТНБД-ын 2025 оны А/50, А/67, А/99, А/108, А/113, А/116, А/117 тоот тушаалын дагуу яамны бараа, ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааг зохион байгуулсан ба ТНБД-ын 2025 оны А/129 дугаар тушаалын дагуу үнэлгээний хороонд ажилласан 8 гишүүдэд нийт 3.9 сая төгрөгийн</p>		
--	------------	--	--	-------------	--	--	--	--	--

							<p>урамшууллыг олгох арга хэмжээ авсан. Түүнчлэн батлагдсан зардлаас худалдан авах бараагаар 11 нэр төрлийн зардлын 730.8 сая төгрөгийн төсвөөс 438.4 сая төгрөг буюу 60%, ажлаар 1 нэр төрлийн зардлын 18.0 сая төгрөгийн төсвөөс 17.9 сая төгрөгийн буюу 99.7 %, үйлчилгээгээр 42 нэр төрлийн зардлын 984.3 сая төгрөгийн төсвөөс 613.0 сая төгрөгийн буюу 62.3 %-н тус тус гүйцэтгэлтэй нийт 54 нэр төрлийн зардлын 1,733.1 сая төгрөгийн батлагдсан төсвөөс 1,069.3 сая төгрөгийн буюу 62%-н гүйцэтгэлтэй хүлээгдэж буй гүйцэтгэл 207.5 сая төгрөг буюу 12%</p>		
--	--	--	--	--	--	--	---	--	--

							<p>зарцуулаагүй гүйцэтгэл буюу төсвөөс үлдсэн хэмнэлт нь 456.2 сая төгрөг буюу 26% гарч ажилласан. Зардлын ангилалаар нь авч үзвэл, ЭШС-ны зардал нь 5 нэр төрлийн ажлын 170.0 сая төгрөгийн төсвөөс 104.4 сая төгрөгийн буюу 61.4% гүйцэтгэлтэй, мэдээлэл судалгааны зардал нь 3 нэр төрлийн зардлын 96.0 сая төгрөгийн төсвөөс 44.9 сая төгрөгийн гүйцэтгэлтэй буюу 46.8%, мэдээлэл технологийн үйлчилгээний зардал нь 28 нэр төрлийн зардлын 592.7 сая төгрөгийн төсвөөс 369.5 сая төгрөгийн буюу 62.3%, төрийн зарим чиг үүргийг</p>		
--	--	--	--	--	--	--	--	--	--

							хувийн хэвшлээр гүйцэтгүүлэх зардал нь 13 нэр төрлийн зардлын 453.8 сая төгрөгийн төсвөөс 328.0 сая төгрөгийн буюу 73.3%, багаж техник хэрэгслийн зардал нь 5 нэр төрлийн зардлын 420.5 сая төгрөгийн төсвөөс 222.3 сая төгрөгийн буюу 52.9%-н тус тус гүйцэтгэлтэй ажилласан.		
3.1.5	Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн төсөл, төсвийн хүрээний мэдэгдэл, төсвийн хязгаарын төслийн саналыг нэгтгэн, боловсруулна	Үйл ажиллагааны зардлаар	Хэрэгжилтийн явц, хувиар	Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн төсөл, төсвийн хүрээний мэдэгдэл, төсвийн хязгаарын төслийн нэгтгэл боловсруулсан.	-	Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн төсөл, төсвийн хүрээний мэдэгдэл, төсвийн хязгаарын төслийн нэгтгэл боловсруулсан байна. /100 хувь/	ТЕЗ-ийн 2026 оны төсвийн хязгаар нийт 207.6 тэрбум төгрөг, үүнээс урсгал 97.7 тэрбум, хөрөнгийн зардал 109.9 тэрбум төгрөг хянагдаж, Төсвийн тухай хуулийн дагуу төсвийн ерөнхийлөн захирагчийн саналыг нийт 407.5 тэрбум, үүнээс урсгал зардал 129.2 тэрбум,	100%	100%

							<p>хөрөнгийн зардал 278.3 тэрбум төгрөгөөр хянан, хязгаараас нийт урсгал зардлыг 31.5 тэрбум, хөрөнгийн зардлыг 168.4 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэн УИХ болон Төрийн Аудитын газар, Сангийн яаманд хуулийн дагуу хүргүүлэн ажилласан.</p> <p>Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуулиар Сайдын багц урсгал зардлыг 134.2 тэрбум, хөрөнгийн зардал 79.7 тэрбум, нийт 213.9 тэрбум төгрөг батлагдсан бөгөөд төсвийн хязгаараас 6.3 тэрбум төгрөг нэмэгдсэн.</p> <p>Шинжлэх ухааны салбарын ажиллагсдын цалинг ТЭЗ саналаас 15 % нэмэгдүүлэн батлагдсан, мөн Шинжлэх ухааны эрдэм шинжилгээ,</p>		
--	--	--	--	--	--	--	---	--	--

						<p>судалгааны зардал нийт 10.0 тэрбум төгрөг батлагдсан. УИХ-аар батлагдсан хөрөнгийн зардалд ТЭЗҮ, зураг төсөв боловсруулахад 21.0 тэрбум, ШУ-ны Нэгдсэн цогцолбор барилгын үлдэх 40.3 тэрбум, тоног төхөөрөмж худалдан авах зардал 18.2 тэрбум төгрөг тус тус батлагдсан. Төсвийн тухай хуулийн дагуу ТЭЗ 2026 оны төсвийн төслийг хуулийн хугацаа болох 7 дугаар сарын 25-ны дотор буюу сайдын 2025.07.23-ны 01/1938 дугаар албан бичгээр Сангийн яам болон Үндэсний аудитын газар, УИХ-ын ажлын албанд хүргүүлсэн. 2026 оны төсвийн төсөл</p>		
--	--	--	--	--	--	---	--	--

42

							<p>танилцуулах хэлэлцүүлгийг Сангийн яам, салбар байгууллагууд, төрийн болон төрийн бус байгууллага, иргэний нийгмийн байгууллага, иргэдийн оролцоотой 2025 оны 8 дугаар сарын 14-ний өдөр зохион байгуулсан.</p> <p>Хэлэлцүүлэгт Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн төсөл, 2026 оны төсвийн төсөл, Шинжлэх ухааны салбарын өнөөгийн байдал, цаашдын бодлого, зорилтыг хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүжилт, салбарын төслийн талаар танилцуулсан.Тус яам нь ТЕЗ-ийн 2026 оны төсвийн төсөлд санал авах ажлыг 14 хоногийн</p>		
--	--	--	--	--	--	--	--	--	--

							хугацаанд Е- Mongolia, 11-11 төв болон байгууллагын цахим хаягаар мэдээлэн, ил тод, нээлттэй явуулан ажилласан.		
3.1. 6	Яамны хөрөнгийн тооллого хийнэ.	Үйл ажиллагаан ы зардлаар	Тооллого хийх тоо/тоо/	2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг нэгтгэн холбогдох байгууллагад хүргүүлсэн.	-	Яамны хөрөнгийн тооллогыг хагас болон бүтэн жилээр тоолсон байна. /2 тооллого/	Албаны хэрэгцээнд ашиглагддаг хөрөнгийн хөдөлгөөнд болон өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтад бүртгэл хийж ажилласан. Тодруулбал, тус онд ЗГХЭГ-аас ТӨБЗГ-ын 2025.10.09-ны өдрийн 475 тогтоолоор 60.5 сая төгрөгийн 17 нэр төрлийн 25 ширхэг тоног төхөөрөмжийг балансаас баланс луу шилжүүлэн авсан. Мөн ТӨБЗГ-т бүтцийн өөрчлөлтөөр шилжсэн Бүсчилсэн хөгжлийн үндэсний хүрээлэнд 16 нэр	100%	100 %

14

							<p>төрлийн 23 ширхэг 88.4 сая төгрөгийн хөрөнгийг, салбар нэгж болон гарсан ТХХТөвд 9 нэр төрлийн 48 ширхэг 101.9 сая хөрөнгийг балансаас балансын хооронд шилжүүлэх хүсэлтээ хүргүүлсэн. Яамны худалдан авалтыг бүртгэхдээ хөрөнгө, бараа материалын нэршил болон кодчиллыг нэг хэв загвартайгаар боловсруулсан бөгөөд хагас жилийн үндсэн хөрөнгийн тооллогыг газар, хэлтэс, хүн тус бүрээр нь шинэчилсэн хөрөнгийн кодчилолтой тулгалт хийж, тооцоо хийсэн. Мөн жилийн эцсийн тооллогыг эхлүүлэн үндсэн хөрөнгийн</p>		
--	--	--	--	--	--	--	--	--	--

						<p>хөдөлгөөн гарсан тухай бүрд тусгай наалттай цаасан дээр эзэмшигчийн нэр, барааны нэр, дүн бар кодтойгоор хэвлэж нааж баталгаажуулан тооцоо бодсон актыг өмч хамгаалах комиссоор оруулахаар бэлтгэл ажил хийгдэж байна. Үүнд: эвдэрч ашиглах боломжгүй үлдэх өртөггүй болсон 4 нэр төрлийн 8 ширхэг 1.5 сая төгрөгийн тавилга эд хогшлыг, 26 нэр төрлийн 33 ширхэг 112.5 сая төгрөгийн тоног төхөөрөмжийг, 2 нэр төрлийн 2 ширхэг 17.9 сая төгрөгийн биет бус үндсэн хөрөнгийг нийт 131.9 сая төгрөгийн хөрөнгийг актлахаар санал оруулахаар, 201 ширхэг 332.6 сая</p>		
--	--	--	--	--	--	--	--	--

							төгрөгийн үндсэн хөрөнгийн хугацааг сунгаж дахин үнэлэхээр тус тус санал оруулж байгаа болно. Түүнчлэн одоогийн байдлаар 3 нэрийн 379.0 сая төгрөгийн авто тээврийн хэрэгсэл, 379 нэрийн 2,147.0 сая төгрөгийн тоног төхөөрөмж, компьютер, 1029 нэрийн 1,296.1 сая төгрөгийн тавилга, эд хогшил, 204 нэрийн 588,8 сая төгрөгийн бусад биет бус хөрөнгүүдийг хийж дуусган хөрөнгүүдийг QR кодыг шинэчлэн хөрөнгө тус бүр дээр наан бүртгэсэн байна.		
3.1.7	Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсөв, санхүүгийн тайланг	Үйл ажиллагааны зардлаар	Тайлангийн тоо/тоо/	Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсөв, санхүүгийн тайланг нэгтгэн	-	Тухай бүр хэрэгжүүлж ажилласан байна./ 8 тайлан/	Холбогдох хууль тогтоомж болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт,	100%	100%

	<p>нэгтгэн гаргана.</p>			<p>холбогдох байгууллагад хүргүүлсэн.</p>			<p>Төсөвт байгууллагын нягтлан бодох бүртгэлийн дансны заавар, төсвийн гүйцэтгэлийн тайлан боловсруулах аргачлал, Эдийн засгийн хөгжлийн яамны нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн дагуу Сайдын эрхлэх асуудлын хүрээний 2024 оны төсөв, санхүүгийн үйл ажиллагааг нягтлан бодох бүртгэлд үнэн зөв тусган хөтөлж, жилийн эцсийн санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайланг боловсруулж санхүүгийн тайлан системд хугацаанд оруулан ажилласан. Жилийн эцсийн санхүүгийн тайланг улсын төсвийн хөрөнгө</p>		
--	-------------------------	--	--	---	--	--	--	--	--

						<p> оруулалтын  санхүүжилтийн  дүн, улсын төсөвт  төвлөрүүлсэн  орлогын дүн,  төрийн сангийн  харилцах дансны  үлдэгдэл  баталгаа гаргах,  арилжааны  банкны дансны  үлдэгдэл, ТЭЗ-  ийн 2024 онд  хэрэгжүүлсэн  хөтөлбөр,  хөтөлбөрийн  хүрсэн үр дүнгийн  талаарх чанарын  тоон үзүүлэлт,  кассын зарлагын  нэгтгэл, төсвийн  гүйцэтгэлийн  тайланг шалгах,  фрийбаланс  программын  гүйцэтгэлтэй  тулган шалгах,  санхүүгийн  тайлан шалгуулж  Сангийн яамны  төрийн сан,  хөрөнгө  оруулалтын  хэлтэстэй тойрох  хуудсаар тооцоо  нийлсэн. ЭЗХЯ-  ны 2025 оны  хагас жилийн  санхүүгийн </p>		
--	--	--	--	--	--	--	--	--

						байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээний тайлан, цэвэр хөрөнгө /өмчийн өөрчлөлт/-ийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тохируулгын тайланг хийж 2025.09.10-10.03- ны дотор үндэсний аудитад баримт болон файлаар мэдээлэл бэлтгэн өгч шалгуулсан. Түүнчлэн Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар ашиглалтад орсон 54 нэр төрлийн 13.933.6 сая төгрөгийн үнэ бүхий ТЭЗҮ, зураг төсвийг хавсралтад заасан холбогдох төрийн болон орон нутгийн өмчит байгууллагын хөрөнгөд бүртгэх ТӨБЗГ-ын 2025.07.08-ны өдрийн 366 тогтоол гарсан бөгөөд одоогоор		
--	--	--	--	--	--	---	--	--

							13 төслийн 5,909.3 сая төгрөгийн ТЭЗҮ-г балансаас баланс луу шилжүүлэн бүртгэлээс хасалт хийгээд байна. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар /БЯ сайдын багц/ бий болсон 3 нэр төрлийн 83 ширхэг 579.4 сая төгрөгийн үнэ бүхий хөрөнгийг ТӨБЗГ-ын 2025.10.09-ны өдрийн 461 тогтоолоор орлогдон авч харьяа байгууллагуудад балансаас баланс руу шилжүүлэн ажилласан.		
3.1. 8	Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр болон шилжин хэрэгжих төслийн ТЭЗҮ, зураг төсвийн гүйцэтгэлийн санхүүжилтийг	Үйл ажиллагааны зардлаар	Санхүүжилтийн явц, хувиар	-	-	Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр болон шилжин хэрэгжих төслийн ТЭЗҮ, зураг төсвийн гүйцэтгэлийн санхүүжилтийг тухай бүрд нь хянан, санхүүжилтийг олгосон байна. /100 хувь/	Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төслийн гүйцэтгэлийг хөрөнгө оруулалт, хөрөнгө оруулалтын барьцаа, техник хяналтын данстуудаар авч үзэхэд: - ХО-ИЗ	100%	100%

	<p>г тухай бүрд нь хянан, санхүүжилтий г шуурхай олгох арга хэмжээ авна.</p>						<p>/66300/ дансны Шинжлэх ухаанаас шилжин ирсэн 2 төслийн 14,552.0 сая төгрөгийн эрх нээлгэснээс 14,235.0 сая төгрөгийн гүйцэтгэлтэй, 2025 оны ШУ-ны 1 төслийн 4,950.9 сая төгрөгийн эрх нээлгэснээс 4,950.9 сая төгрөгийн гүйцэтгэлтэй, 2025 оны ТЭЗҮ-н 9 төслийн 1,198.5 сая төгрөгийн эрх нээлгэснээс 1,196.1 сая төгрөгийн гүйцэтгэлтэй, концессийн 10,983.4 сая төгрөгийн эрх нээлгэснээс 10,983.4 сая төгрөгийн гүйцэтгэлтэй нийт 31,365.5 сая гүйцэтгэлтэй гарсан. ХО-ын /ЛОТ/ концессын гэрээгээр 26,699.7 сая төгрөгийн орлого орж ирснийг</p>		
--	--	--	--	--	--	--	---	--	--

						<p>улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн болно. - Хөрөнгө оруулалтын барьцаа /66350/ дансанд 73 төслийн 81,454.8 сая төгрөгийн эрх нээлгэснээс 57 төслийн 23,178.9 сая төгрөгийн гүйцэтгэлтэй гарсан бөгөөд улсын төсөвт 7 төслийн 6,644.9 сая төгрөгийг төвлөрүүлсэн. Барьцаа хөрөнгийн дансанд 15 төслийн 199.9 сая төгрөгийн барьцаа суутган байршуулж, 40 төслийн 275.7 сая төгрөгийг суутган техник хяналтын зардлын данс руу шилжүүлэн байршуулсан. - ХО-Техник хяналт /66370/ -ын дансанд 40 төслийн гүйцэтгэлээс суутгал хийгдсэн 275.7 сая төгрөгийн</p>		
--	--	--	--	--	--	--	--	--

							<p>техникийн зардлыг барьцаа данснаас нэмж орлогдсон бөгөөд бүрэн дуусгавар болсон техник хяналтын зардлын хяналт тавьсан байгууллагууд болох БХТ-д 3 төслийн 21.4 сая, ЗТЯ-д 8 төслийн 97.1 сая, НЗХГ-т 10 төслийн 90.0 сая, Завхан аймгийн ЗДТГ-т 1 төслийн 8.4 сая, Дархан-уул аймгийн ЗДТГ-т 1 төслийн 14.4 сая төгрөгөөр нийтдээ 231,5 сая төгрөгийн гүйцэтгэлийг олгосон. ШУ-ны төслийн зохиогчийн хяналтын зардлыг хянан тооцож Жаргалант хийц ХХК-д 139.6 сая төгрөгийг олгосон. Мөн тус дансны өмнөх оны үлдэгдэлээс концессийн 1 төслийн 1,420.4</p>		
--	--	--	--	--	--	--	--	--	--

							сая төгрөгийн гүйцэтгэл олгож улсын төсөвт 1,125.7 сая төгрөгийн аудитын актын дагуу улсын төсөвт татан төвлөрүүлсэн.		
--	--	--	--	--	--	--	---	--	--

Үнэлсэн:



И.Батхүү

Төрийн нарийн бичгийн дарга  
(албан тушаал)

И.Батхүү  
(гарын үсэг)

2025.12.15  
(огноо)

Тайлагнасан:

Санхүүгийн хэлтсийн даргын  
албан үүргийг түр  
орлон гүйцэтгэгч  
(албан тушаал)

Ж.Гэрэлбат

Ж.Гэрэлбат  
(гарын үсэг)

2025.12.15  
(огноо)